

**2020 ОНООС ЭХЛЭН ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ЗАХИАЛГАТ ТӨСЛИЙГ  
ДАРААХ ЧИГЛЭЛҮҮДЭЭР ЗАРЛАЖ БАЙНА**

№	Төслөөр шийдвэрлүүлэх асуудал, хугацаа	Үр дүнгийн талаарх төсөөлөл
<b>Засгийн газрын Хэрэг эрхлэх газар</b>		
1.	<p>“Монгол Улсын тогтвортой хөгжил 2030”-ын эхний шатны хэрэгжилтийн үнэлгээ</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэгжилтийн үе шат бүрийн үр дүнг зорилт бүрээр үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, арга зүй, аргачлалыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилтуудын эхний шатны үр дүнд үнэлгээ хийх;</li> <li>- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д дэвшүүлсэн зорилтууд болон тэдгээрийн хэрэгжилтийн явцыг Монгол Улсын бодлогын бусад баримт бичгүүдийн зорилт, хэрэгжилттэй харьцуулан цогц дүн шинжилгээ хийх;</li> <li>- Бодлогын нэгдмэл цогц байдал, уялдаа холбоотой, залгамж шинжийг үндэсний болон бүс нутгийн хэмжээнд тодорхойлох;</li> <li>- Салбарын болон салбар дамнасан бодлогын баримт бичгүүдийн үзэл баримтлал, тэргүүлэх чиглэлийг харьцуулан судалж нэгдсэн дүгнэлт гаргах;</li> <li>- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын гол зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлыг төслийн хүрээний мэдэгдэл, улсын төсөвт хэрхэн тусгагдаж ирсэнд дүн шинжилгээ хийх;</li> <li>- “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын зорилт, тэдгээрийн хэрэгжилтийн явц Монголын нийгэм, улс төрийн тогтолцоо, засаглалаас хэрхэн хамаарч байгаад дүн шинжилгээ хийж үнэлэлт дүгнэлт гаргах;</li> </ul>
2.	<p>Төрийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах үйл ажиллагаанд хэрэглэх нь</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн үйл ажиллагааны энтерпрайз архитектур, бизнес процес, мэдээллийн урсгал, мэдээллийн багтаамж, суурь мэдээллийн шинжилгээ хийх;</li> <li>- Төрийн мэдээлэл солилцооны стандарт, бүтцийн шинжилгээ бүхий төрийн мэдээлэл солилцооны дундын платформын техникийн даалгавар боловсруулах;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Төрийн мэдээлэлд дүн шинжилгээ, харьцуулалт хийх, шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах арга замыг тодорхойлох;</li> <li>- Төрийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, хөгжүүлэх технологийн шийдэл боловсруулах;</li> </ul>
3.	Монгол Улсын хот суурины стратеги, төлөвлөлт  2020-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын хот суурины хөгжлийн нөхцөл байдлын шинжилгээ, үнэлэлт, дүгнэлт;</li> <li>- Монгол Улсын хүн амын нутагшилт, сууршил, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан хот сууринг төлөвлөх онол арга, зүй;</li> <li>- Монгол Улсын хот суурины хөгжлийн үзэл баримтлал, суурь зарчим;</li> <li>- Монгол Улсын хорин нэгдүгээр зууны хот суурины стратеги, төлөвлөлт, онолын үндэслэл;</li> </ul>
<b>Байгаль орчин, аялал жуулчлалын яам</b>		
4.	Ургамлаас биологийн идэвхт бодис нийлэгжүүлэх эндофит бичил биетний өсгөвөр ялгаж өсгөврийн сан бүрдүүлэх, тэдгээрт суурилсан бүтээгдэхүүний туршилт судалгаа  2020-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол орны устаж байгаа, ховор болон ашиглалтад хэт өртөмтгий эмийн ургамлуудаас эндофит бактери, мөөгөнцрийн өсгөвөр ялган авч, тэдгээрийг молекул маркер ашиглан тодорхойлж, ex-situ хамгаалах;</li> <li>- Эндофит бичил биетний өсгөврийн болон мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийг дэлхийн бичил биетний глобал каталогт байршуулах;</li> <li>- Эндофит бичил биетний микробын эсрэг идэвх, хавдрын эсрэг идэвх, ургамлын өсөлтийг дэмжих чадвар зэрэг биологийн идэвхийг нарийвчлан судлах;</li> <li>- Шинэ бодис эсвэл эзэн ургамалтайгаа адил эмт бодис нийлэгжүүлж буй эсэхийг тогтоож, тэдгээрийг хэрэглээнд ашиглахад чиглэсэн туршилт судалгаа хийх;</li> </ul>
5.	Хөх ногоон замгийн хор ялгаруулагч зүйлүүд, олон янз байдал, биологи, нөөцийн судалгаа  2020-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Хөх ногоон замгийн зүйлийн бүрэлдэхүүн, зүйл тус бүрийн арви, нягтшилыг тодорхойлох;</li> <li>- Ургалтын эрчимтэй үе, хугацааг тодорхойлж, хор ялгаруулагч хөх ногоон замгийн зүйлийн идэвхжилийн үе, ялгаруулах хорны хэмжээ, хоруу чанарыг тогтоох;</li> <li>- Загас, усны амьтдад үзүүлэх нөлөөллийг үнэлэх;</li> <li>- Нуурын усны биобохирдлыг хянах, үнэлэх мониторингийн аргачлал боловсруулах;</li> </ul>
6.	Байгалийн болон тарималжуулсан зарим зүйл ургамлын морфологи, хөгжлийн үе шат, биохими, химийн найрлагыг харьцуулан судлах	<ul style="list-style-type: none"> <li>- Байгалийн болон тарималжуулж буй зүйлүүд /Дэрэвгэр жиргэрүү, Урал чихэр өвс, Байгаль гүүн хөх, Долгиотсон гишүүнэ, Сарьслаг хунчир, Нангиад зээргэнэ/-ийн</li> </ul>

	2020-2022	<p>биоморфологи, ашиглагдах хэсгийн гарц, ургах орчныг харьцуулан судлах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байгалийн болон тарималжуулж буй зүйлүүдийн биологийн идэвхт бодисын найрлага, хэмжээг харьцуулан судалж, жагсаалт гарган тэдгээрийн нийлэгжлийн ялгааг молекул биологийн аргаар тогтоож, нийлэгжилд оролцдог генийн нуклеотидын дарааллыг дэлхийн генийн санд бүртгүүлэх;</li> <li>- Байгалийн болон тарималжуулж буй зүйлийн вегетацийн хугацаа, хөгжлийн үе шатыг харьцуулж, орчиндоо дасан зохицож буйд үнэлэлт дүгнэлт өгөх, шаардагдах органик агро арчилгааны технологи заавар боловсруулах;</li> <li>- Байгалийн болон тарималжуулсан ургамлаас бэлтгэсэн түүхий эдийг өөр хооронд нь ялгах шинж, шалгах арга стандартыг боловсруулах, үрийн нөөц бий болгох;</li> </ul>
<b>Гадаад харилцааны яам</b>		
7.	<p>Монгол – Орос – Хятадын гурван талын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт байгалийн хий дамжуулах хоолой, эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх боломжийн судалгаа</p> <p>2020</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол-Орос-Хятадын гурван талын хамтын ажиллагааны хүрээнд байгалийн хий дамжуулах хоолой барих, эрчим хүчний төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчныг судлах, бодлогын зөвлөмж боловсруулах;</li> <li>- Монгол Улсын нутаг дэвсгэрээр Оросын Холбооны Улсаас Бүгд Найрамдах Хятад Ард Улс руу байгалийн хий дамжуулах хоолой барих нөхцөлийг тодорхойлох;</li> <li>- “Зүүн хойд Азийн цахилгаан эрчим хүчний нэгдсэн сүлжээ” байгуулах нөхцөлийг тодорхойлох;</li> <li>- Хий дамжуулах хоолой барих болон эрчим хүчний төслийн эдийн засгийн үр ашгийн урьдчилсан тооцоог хийх;</li> </ul>
8.	<p>Оросын Холбооны Улс болон Бүнд Найрамдах Хятад Ард Улсын дотоод, гадаад бодлогын Евразийн бүс нутаг дахь нөлөө, харилцан ажиллагааны харьцуулсан судалгаа</p> <p>2020</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Орос, Хятадын Евразийн бүс нутаг дахь нөлөө, байр суурь, бодлогын өөрчлөлтийг харьцуулан судлах;</li> <li>- Монгол Улсын улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд /гадаад худалдааны зах зээлээ тэлэх, эдийн засгаа төрөлжүүлэх, дамжин өнгөрөх тээврээс олох ашиг орлогоо нэмэгдүүлэх, бүс нутаг дахь нэр хүнд байр сууриа бэхжүүлэх зэрэг/-ыг уялдуулан судалж бодлогын зөвлөмж гаргах;</li> <li>- Орос Хятадын эрх ашгийн зөрчил болон стратегийн түншлэлийн ойртолт, түүний Монгол Улсад нөлөөлөх байдал, Монголын талын бодлого, санал, зөвлөмж;</li> </ul>

**Хууль зүй, дотоод хэргийн яам**

9.	Ховор, нэн ховор ан амьтан хууль бусаар агнасан болон мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэхэд митохондрийн ДНХ-ийн арга технологийг шүүхийн шинжилгээний практикт нэвтрүүлэх туршилт, судалгаа  2020-2022	<ul style="list-style-type: none"> <li>- Гэмт хэрэг, зөрчлийн хэрэгт ан амьтны гаралтай түүхий эдийн зүйлийн харъяалалыг <i>Scientific Working Group on DNA Analysis Methods</i> / (SWGAM)/-ийн зөвлөмжид тулгуурлан митохондрийн ДНХ-ийн шинжилгээгээр тогтоох аргачлалыг боловсруулах;</li> <li>- Митохондрийн ДНХ-ийн шинжилгээний арга технологийг ашиглан туршилт судалгаа хийж, үр дүнг шүүхийн шинжилгээнд нэвтрүүлэх;</li> </ul>
10.	Иргэдийн эрх зүйн соёлын төлөвшил: Одоогийн төлөв байдал, чиг хандлага  2020-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Хүний эрхийг хангах, хамгаалах төр засгийн бодлого болон хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх иргэд, олон нийтийн байр суурь, хандлагад дүн шинжилгээ хийх;</li> <li>- Иргэдийн амьдралд түлхүү ашигладаг эрх зүйн баримт бичгүүдийн өөрчлөлтийн давтамж, тогтворгүй байдлын шалтгаан, үр дагаврын цогц судалгаа явуулах;</li> <li>- Иргэдийн эрх зүйн ухамсар, эрх зүйн соёлын өнөөгийн төлөв байдалд цогц судалгаа хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт гаргах;</li> <li>- Иргэдийн эрх зүйн ухамсар, эрх зүйн соёлыг дээшлүүлэх талаар /төр засаг, хууль хяналт-мэргэжлийн байгууллага, эрдэм шинжилгээ, сургалт, төрийн бус байгууллагуудад хандсан/ бодлогын зөвлөмж бэлтгэх;</li> </ul>

**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам**

11.	Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийг тодорхойлох  2020	<ul style="list-style-type: none"> <li>- Залуучуудын нийгэм, улс төрийн оролцоо, нас, сэтгэхүй, бие бялдар, түүх соёлын хөгжлийн ерөнхий судалгаа;</li> <li>- Залуучуудын хөгжилд нөлөөлж буй эерэг, сөрөг болон хөгжлийг хязгаарлах хүчин зүйлүүдийн судалгаа;</li> <li>- Зорилтот бүлгийн залуучуудын хөгжлийн нөхцөл байдлын судалгаа;</li> <li>- Залуучуудын хөгжлийн талаарх хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт өгөх, цаашдын бодлого, хөтөлбөрийн зөвлөмж боловсруулах;</li> </ul>
12.	Монгол Улс дахь ядуурлыг бууруулж, дундаж давхаргын эгнээг өргөжүүлэх боломжийн судалгаа  2020-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Хүн амын ядуурал, дундаж давхаргын түвшинг нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан дэлгэрэнгүй судлах;</li> <li>- Амьжиргааны түвшинд нөлөөлөх хүчин зүйлсийг судалж, амьжиргааны түвшинг тодорхойлох арга зүй боловсруулах;</li> <li>- Олон улсад амьжиргааны түвшинг тодорхойлдог аргуудыг харьцуулан судалж,</li> </ul>

		<p>Монгол Улсын хүн ам, өрхийн орлого, зарлагын судалгаа хийх;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хүн амын дундаж давхаргыг бүтэц, хэв шинжийг тодорхойлох шалгуур үзүүлэлт боловсруулах;</li> <li>- Иргэдийн амжиргааны болон амьдралын чанарыг сайжруулах, ядуурлыг бууруулах, тасралтгүй, хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг бий болгох нөөц, нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа;</li> <li>- Монгол Улс дахь ядуурлыг бууруулж, дундаж давхаргын эгнээг өргөжүүлэх зөвлөмж боловсруулах;</li> </ul>
<b>Батлан хамгаалах яам</b>		
13.	<p>Үндэсний ой санамж, үнэт зүйлсийг сэргээн тодорхойлох замаар үндэсний аюулгүй байдлыг бэхжүүлэх нь</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний ой санамж, үнэт зүйлсийн иж бүрэн судалгаа хийх;</li> <li>- Төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, төрийн албан хаагчдыг сурган бэлтгэх чиглэлээр зөвлөмж боловсруулах;</li> <li>- Үндэсний ой санамж, үнэт зүйлсийн талаарх заавал мэдвэл зохих мэдлэг, мэдээллийг бүх насныханд түгээн дэлгэрүүлэх арга, аргачлал боловсруулах;</li> </ul>
14.	<p>Монгол Улсын аюулгүй байдлыг хангахад “гуравдагч хөрш”-ийн бодлогын үзүүлэх нөлөөлөл</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Гуравдагч хөрш”-ийн бодлогын онол, арга зүй, шинжлэх ухааны үндэслэлийг тодорхойлох;</li> <li>- Монгол Улсын оршин тогтнохуйн аюулгүй байдалд үзүүлэх “гуравдагч хөрш”-ийн бодлогын нөлөөллийг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах;</li> <li>- Монгол Улсын оршин тогтнохуйн аюулгүй байдалд гуравдагч хөршийн бодлогын үзүүлэх нөлөөг нийтэд таниулах арга боловсруулах;</li> </ul>
15.	<p>Тийрэлтэт сумны хатуу түлш үйлдвэрлэх технологи боловсруулах</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS ISO 21500:2017 стандартыг хангасан хатуу түлш үйлдвэрлэх технологи боловсруулах;</li> <li>- Хатуу түлшийг өөрийн эх орны байгалийн баялаг, эрдэс түүхий эд болон уул уурхай, хүнд аж үйлдвэрийн хаягдал, илүүдэл бүтээгдэхүүнийг ашиглан дотооддоо үйлдвэрлэх судалгаа;</li> <li>- МРД, ПРД загварын пуужингийн түлш үйлдвэрлэлийн судалгаа;</li> <li>- Хатуу түлшийг ашиглан гранатомётын сургалтын гранат үйлдвэрлэх технологи;</li> <li>- Сургалтын гранатыг цэргийн сургалт, бэлтгэлд ашиглах судалгаа;</li> </ul>

16.	Монголын хүн ам, удмын сангийн аюулгүй байдлын судалгаа  2020-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Монголын хүн ам, удмын сангийн аюулгүй байдлын шинжилгээ, судалгаа /18-25 нас/;</li> <li>- Хүн ам, удмын сангийн аюулгүй байдлын сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн динамик загвар боловсруулах;</li> <li>- Монголын хүн ам, удмын сангийн аюулгүй байдалд чиглэсэн төрийн бодлогын шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах;</li> </ul>
<b>Барилга, хот байгуулалтын яам</b>		
17.	Өндөр болон онцгой хариуцлагатай барилгын газар хөдлөлтийн үйлчлэлийг тооцсон динамик тооцооны өгөгдлүүдийг боловсруулах  2020-2022	<ul style="list-style-type: none"> <li>- Өндөр болон онцгой хариуцлагатай барилга байгууламжийн динамик тооцоонд хэрэглэх тухайн талбайн хөрсний өгөгдөл хэлбэлзлийн хурдатгалын бичлэгт тавигдах шаардлага;</li> <li>- Хурдатгалын бичлэгийг ашиглан барилга байгууламжийн талбайн спектр муруйг гаргах аргачлал;</li> <li>- Өндөр барилгын болон онцгой хариуцлагатай барилга байгууламжийн динамик тооцоонд хэрэглэх хөрсний хэлбэлзлийн хурдатгалын зохиомол бичлэг;</li> <li>- Өндөр барилга байгууламжийн динамик тооцоонд хэрэглэх нормын спектр муруйд тавигдах шаардлага;</li> </ul>
18.	Хүйтний улиралд бэхжүүлсэн бетоны нүх сүвийн бүтэц, тархалтын судалгаа  2020-2021	<ul style="list-style-type: none"> <li>- Цутгалтын ажлыг хүйтний улиралд гүйцэтгэх талаар баримталж буй салбарын норм ба дүрмийг шинэчлэх үндэслэлийг судалгаанд суурилан гаргах;</li> <li>- Хүйтний улиралд цутгалтын ажлыг гүйцэтгэх технологи боловсруулах;</li> <li>- Хүйтний улиралд цутгаж бэхжүүлсэн бетон, төмөр бетон бүтээцийн нүх сүвийн бүтэц, нүх сүвийн хэмжээ, тархалтыг судлах, бүтээцэд үзүүлж буй нөлөөлөл, сөрөг үр дагаврыг даван туулах арга замыг судлах;</li> <li>- Гадна агаарын температур хэт доошилсон өвлийн саруудад бетоныг бэхжүүлэх арга технологи;</li> <li>- Хүйтний улиралд цутгалтын ажлыг гүйцэтгэх арга технологи, хүний нөөцийн сургалт, судалгаа;</li> </ul>
<b>Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам</b>		
19.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дасан зохицох, зан үйлийг үнэлэх дэвшилтэт арга, технологи  2020	<ul style="list-style-type: none"> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дасан зохицох зан үйлийг үнэлэх "VABS-3" үнэлгээний арга аргачлалыг нутагшуулан хэрэглэх стандарт, судалгаа;</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дасан зохицох зан үйлийг үнэлэх арга аргачлалыг туршсан туршилтын үр дүн, дүгнэлт;</li> <li>- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг багш, мэргэжилтнүүдэд зориулсан үнэлгэний</li> </ul>

		аргачлалыг хэрэглэх гарын авлага, заавар, зөвлөмж;
20.	9-11 насны хүүхдүүдийн өсөлтийн индекс, нурууны хазайлт мурийлтыг тодорхойлох судалгаа  2020	<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэл, орон нутгаас тус бүр 500 хүүхдийг түүврийн аргаар сонгон нурууны хазайлт, мурийлтыг тодорхойлох судалгаанд хамруулан судалсан нөхцөл байдлын судалгаа;</li> <li>- Судалгааны үр дүнд үндэслэн өсвөр насны хүүхдийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрийн агуулгад өөрчлөлт оруулах, зохион байгуулах талаар боловсруулсан заавар, зөвлөмж;</li> <li>- Өсвөр насны хүүхдүүдийн бодисийн солилцооны талаарх тойм мэдээллийг бүрдүүлэх заавар, зөвлөмж;</li> </ul>
21.	Соёл урлагийн салбарын статистикийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах  2020	<ul style="list-style-type: none"> <li>- Соёл урлагийн салбарын статистикийн шалгуур үзүүлэлтийг олон улсын /ЮНЕСКО/ стандартад нийцүүлэн боловсруулах;</li> <li>- Соёлын урлагийн салбарын сүүлийн жилүүдийн статистикийн мэдээллийн боломжит эх үүсвэрийг ашиглан шалгуур үзүүлэлтийн тооцоолол хийх;</li> <li>- Соёлын урлагийн салбарын үндэсний статистикийн шалгуур үзүүлэлтийг тооцоолох арга зүй, аргачлал боловсруулах;</li> </ul>
22.	Боловсролын салбарын эрсдэлт хүчин зүйлийн судалгаа  2020	<ul style="list-style-type: none"> <li>- Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын орчин, чанарт сөрөг нөлөө үзүүлж буй эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх шалгуур үзүүлэлтүүд;</li> <li>- Хууль эрх зүйн орчны тогтвортой бус байдлаас үүсч буй эрсдэлийн үзүүлэлтүүд;</li> <li>- Хүн амын тоо, газар зүйн байршил, цаг уурын хүчин зүйлс нь тухайн бүс нутгийн боловсролын чанарт хэрхэн нөлөөлж байгаас хамаарч үүсэх эрсдлийн үзүүлэлтүүд;</li> <li>- Боловсролын байгууллагын үйл ажиллагаа, сургалтын орчин, чанарын эрсдлийг үнэлэх, бууруулах талаар боловсруулсан арга, аргачлал, зөвлөмж;</li> </ul>
23.	Хүүхэд залуучуудын урлагийн боловсрол, гоо зүй, ёс зүйн хүмүүжил, төлөвшилд төр, олон нийтийн оролцоог идэвхжүүлэх нь  2020	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхэд залуучуудын урлагийн боловсрол, ёс зүй, гоо сайхны мэдрэмжийг хөгжүүлэхэд төр болон төрийн бус байгууллагын зүгээс хийгдэж буй ажлын чиглэл, үр нөлөөний нөхцөл байдлын шинжилгээ, судалгаа;</li> <li>- Өсвөр насны хүүхдүүдийн соёлын болон урлагийн боловсрол, ёс зүй, уран сайхан гоозүйн мэдрэмж, төлөвшилд мэдээллийн технологи, дижитал орчин болон багшийн ёс зүйн нөлөөллийг судлах;</li> <li>- Соёлын болон урлагийн боловсрол, багшийн ёс зүйн боловсролоор дамжуулан өсвөр</li> </ul>

		<p>насны хүүхдүүдийн ёс зүй, гоо зүйн мэдрэмж, төлөвшил, хандлагыг тодорхойлох үнэлгээний аргачлал;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Судалгааны үр дүнг боловсролын салбарын бүх түвшинд нэвтрүүлэх төрийн бодлогын баримт бичиг боловсруулах санал, зөвлөмж;</li> </ul>
24.	<p>Боловсролын салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх бодлого боловсруулах судалгаа</p> <p>2020</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Боловсролын салбарын мэдээллийн технологийн нөхцөл байдлын судалгаа;</li> <li>- Боловсролын салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх бодлогын үзэл баримтлал, бодлогын баримт бичгийн хувилбар боловсруулах;</li> <li>- Бодлого хэрэгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөө, төсвийн төсөөлөл;</li> </ul>
25.	<p>Эрдэм шинжилгээний ажлын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх арга</p> <p>2020</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрдэм шинжилгээний ажлын чанар, үр дүн, үр өгөөжийг үнэлэх шалгуур үзүүлэлт, арга, аргачлал, хэрэглэх заавар, гарын авлага;</li> <li>- Төслийн ангилал тус бүрт тавигдах шаардлага, шалгуур, сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох, тэдгээрт нийцүүлэн боловсруулсан мэдүүлгийн маягт, заавар, стандарт;</li> <li>- Төслийн захиалагч, гүйцэтгэгч, санхүүжүүлэгчийн эрх үүргийг тодорхойлох, төслийн гэрээнд оюуны өмчийн эрхийн хамгаалалт, ашиглалтын зохицуулалт;</li> <li>- Төслийн явцын болон төслийн үр дүнгийн тайлагнал, ашиглалтад мониторинг хийх үнэлгээний аргачлал;</li> </ul>
<b>Зам, тээврийн хөгжлийн яам</b>		
26.	<p>Хүйтэн асфальтбетон үйлдвэрлэх судалгаа</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол орны зам, цаг уурын бүсэд тохирсон сайжруулсан битум бүхий хүйтэн асфальт бетон үйлдвэрлэх арга, технологи боловсруулах;</li> <li>- Жилийн дөрвөн улиралд автозамын засвар, арчлалт хийх технологийн горимыг тогтоох;</li> <li>- Хүйтэн асфальтбетон хольцыг үйлдвэрлэн савлаж, хадгалах, хэрэглэх арга, аргачлал боловсруулах;</li> </ul>
27.	<p>Бага өртөгтэй тээвэрлэгчдийн бизнес загварыг Монгол Улсад хөгжүүлэх арга зам</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хямд өртөгтэй тээвэрлэгчийн бизнес загварыг хөгжүүлж байгаа олон улсын туршлага, харьцуулсан судалгаа;</li> <li>- Иргэний нисэхийн салбарт тээвэрлэгчийн үйл ажиллагааны зардлыг багасгах арга замыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нарийвчлан судлах;</li> <li>- Монгол орны онцлогт тохирсон хямд өртөгтэй тээвэрлэгчийн бизнес загварыг боловсруулах;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Хямд өртөгтэй тээвэрлэгчийн бизнес загварыг хөгжүүлэх эрхзүйн орчныг сайжруулах судалгаа, зөвлөмж;</li> </ul>
28.	<p>Зам, тээврийн салбарын нэгдсэн тээврийн системийг хөгжүүлэх судалгаа</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зам, тээврийн салбарын нэгдсэн тээврийн системийн өнөөгийн нөхцөл байдал, бодлогын баримт бичиг, стандартын судалгаа;</li> <li>- Зам, тээврийн салбарын мэдээллийн урсгалын нөхцөл байдлын судалгаа, дижитал шилжилтийн системийн шийдэл, процесс, бүтэц, энтерпрайз архитектурыг боловсруулах, нэвтрүүлэхэд шаардлагатай төсвийг тооцоолох;</li> <li>- Салбараас иргэд, хуулийн этгээдэд үзүүлдэг үйлчилгээнүүдийг цахимжуулахад шаардлагатай дүрэм, журмын судалгааг хийж, шаардлагатай баримт бичгийн төсөл боловсруулах;</li> <li>- Бусад байгууллагатай мэдээлэл солилцох боломж, төрийн мэдээлэл солилцооны цахим системээр дамжуулан салбарын үйл ажиллагааг сайжруулах аргачлал боловсруулах;</li> </ul>
29.	<p>Зам тээврийн ослын шалтгаан нөхцөлд хүн, тээврийн хэрэгсэл, замын нөлөөллийн судалгаа</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зам тээврийн осолд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгааг нарийвчлан гаргах;</li> <li>- Зам тээврийн ослоос сэргийлэх олон улсын туршлага, монгол орны нөхцөлд нэвтрүүлэх боломжийн судалгаа;</li> <li>- Зам тээврийн ослын шалтгаан нөхцөлд хүн, тээврийн хэрэгсэл, зам, байгалийн гамшгийн нөлөөллийг бууруулах арга зам, зөвлөмж;</li> </ul>
30.	<p>Идэвхжүүлсэн эрдэс нунтаг ашиглан асфальтбетон хучилтын бат бэхийг сайжруулах судалгаа</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Идэвхижүүлсэн эрдэс нунтгийг ашиглан асфальтбетоны бат бэхийг сайжруулах судалгаа;</li> <li>- Идэвхжүүлсэн эрдэс нунтагийн хольцтой асфальт бетон үйлдвэрлэх технологи, үр ашгийн тооцоог боловсруулах;</li> </ul>
31.	<p>Улаанбаатар хотын нийтийн тээврийн эрэлт, сүлжээ төлөвлөлтийн судалгаа</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын иргэдийн зорчих эрэлтийн судалгаа;</li> <li>- Улаанбаатар хотын нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийн өнөөгийн байдлын судалгаа, дүн шинжилгээ хийх;</li> <li>- Улаанбаатар хотын иргэдийн зорчих эрэлтийн загварыг тээврийн төлөвлөлтийн мэргэжлийн програм хангамж дээр боловсруулах;</li> <li>- Нийтийн тээврийн сүлжээ төлөвлөлтийг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсронгуй болгох арга, зөвлөмж боловсруулах;</li> </ul>

32.	<p>Давхар ачилгат чингэлгийн вагоныг төмөр замын тээвэрлэлтэд нэвтрүүлэх</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Давхар ачилгат чингэлгийн галт тэргийг төмөр замын тээвэрлэлтэд нэвтрүүлэх нөхцөл, шаардлагын судалгаа;</li> <li>- Монгол орны цаг уурын нөхцөл, салхины хурд, хүчний нөлөөллийн судалгаа;</li> <li>- Монгол орны нөхцөлд нийцэх давхар ачилга хийх чингэлгийн төрөл, даац, хийц, ашиглалт, засварын судалгаа;</li> <li>- Давхар ачилгат чингэлгийн галт тэрэг Монголын Улсын төмөр замын тахир тойрууд өнгөрөх хурдны дээд хязгаарыг тогтоох, татах тооцоо хийж үнэлгээ гаргах;</li> <li>- Давхар ачилгат чингэлгийн галт тэргийг төмөр замын тээвэрлэлтэд нэвтрүүлэх технологи, техникийн шаардлагыг боловсруулах;</li> </ul>
<b>Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам</b>		
33.	<p>Монгол орны хэмжээнд тархсан "Критикал металл"-уудын хүдэржилт, хэтийн төлвийн судалгаа</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол орны хэмжээнд тархсан "Критикал металл"-уудын хүдэржилтийн талаарх мэдээллийн сан байгуулах;</li> <li>- "Критикал металл"-уудын хүдэржилтийг хянагч геологийн хүчин зүйлүүдийг тодруулах (ГХЭ, ЦАБ, Li, Co, Ta, Nb, Gr, In, Mg гм);</li> <li>- Эдгээр металлууд бүхий талбайн геологийн тогтоцыг тодруулж дээжлэлт хийх;</li> <li>- "Критикал металл"-уудын металлын агуулга, найрлага, эрдэслэг бүрэлдэхүүн, хүдэржилтийн төрөл зэргийг тодорхойлох, ангилах;</li> <li>- "Критикал металл"-уудын Монгол орны хэмжээнд тархалт, байршлын зүй тогтолыг гаргаж, хэтийн төлөвт үнэлгээ өгч, цаашдын геологи хайгуулын ажлын зөвлөмж гаргах;</li> </ul>
34.	<p>Нуурын хөндийн хагарлын зүй тогтлын судалгаа</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Нуурын хөндийн хагарлын зүй тогтлын судалгаа хийх;</li> <li>- Хагарлын нутгийн идэвхтэй хагарлуудын шинж чанар, хүчтэй газар хөдлөлтийн давтагдалт болон геодинамикийн нөхцлийг судлах;</li> </ul>
<b>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам</b>		
35.	<p>Сарлагийн эко хэвшлийн олон янз байдалд өвөрмөц байдлын хамаарал, нөлөөллийг фено, гено шинж тэмдгийн илрэлээр тогтоох нь</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Сарлагийн өсөлт, хөгжил ба үржил-ашиг шимт чанарын зүй тогтолт хамаарал, түүний шалгуур үзүүлэлт;</li> <li>- Тугал, өсвөр насны сарлагийг чиглэлтэй өсгөн бойжуулах маллагааны ба тэжээллэгийн технологи;</li> <li>- Сарлагийн нөхөн үржихүй, үндсэн ашиг шимд тэжээллэгийн үзүүлэх нөлөөг туршсан дүн, үнэлгээ;</li> <li>- Сүрэгт хээлтэгчийн хувийн жинг нэмэгдүүлэх замаар өсвөр насны сарлагийн махны</li> </ul>

		<p>үйлдвэрлэлийн зохистой хувилбар, сүргийн эргэлтийн бизнес загвар;</p>
36.	<p>Хангай, Орхон, Тал нутгийн цагаан үүлдрийн нарийн, нарийвтар ноост хонинд селекцийн эх сүрэг бүрдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үүлдрийн үндсэн ашиг шимийн параметрийг тодорхойлж, түвшингийн үнэлгээ, селекцийн ялгаа, чиглэл гаргах;</li> <li>- Генотипүүдийн ашигтай, онцлог давуу шинжүүд (ноосны гарц, ноосны урт, нарийн, атираа, бөх бат, жигдлэг г.м)-ийн удамших аж ахуйн ашигтай шинжүүдийг нэгтгэсэн селекийн эх сүрэг бүрдүүлэх (Хангай, Орхон, Тал нутгийн цагаан үүлдэр тус бүрт 250 толгой);</li> <li>- Нарийн, нарийвтар ноост хонины байгалийн бэлчээр, таримал бэлчээр ашиглах ялгааг тогтоож, хосолсон маллагааны технологи боловсруулах;</li> <li>- Төл, өсвөр хонины өсөлтийн хөдлөл зүй, эдийн засгийн эргэлтэд эрт оруулах боломжийг судлан тогтоох;</li> <li>- Ноос, арьсны чанарын лабораторийн тодорхойлолт гаргах;</li> <li>- Нарийн, нарийвтар ноост хонины хурганы арьсыг ашиглах туршилтыг явуулж, хурганы арьсны стандарт боловсруулах, батлуулах;</li> </ul>
37.	<p>Үхрийн хөврөлийн чанар, амилалтад нөлөөлөгч маркер генүүдийг тодорхойлох, зарим үүлдрийн үхрийн нуклеотидийн дарааллыг тогтоох</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Донор үнээнээс зайлж авсан намираа хучуур эсийг судлан үхрийн хөврөлийн чанарт нөлөөлөх генүүдийг тодорхойлж, тухайн генүүдийн нуклеотидийн дарааллыг тогтоох;</li> <li>- Донор үнээнээс мэс заслын бус аргаар хөврөл зайлан авч, тээгч үнээнд шилжүүлэн суулгах технологийг Монгол оронд нутагшуулах;</li> <li>- Зайлж авсан I, II зэргийн хөврөлийг гүн хөлдөөх, хадгалах технологийг боловсруулах;</li> <li>- Гүн хөлдөөсөн хөврөлөөр генийн санг баяжуулах;</li> <li>- Алатау, түүний эрлийз үхрийн болон Монгол үүлдрийн үхрийн удам зүйн ялгааг генийн нуклеотидийн дарааллаар тодорхойлох;</li> <li>- Донор болон тээгч үхрийн арчилгаа, маллагаа, тэжээллэгийн зөвлөмж боловсруулах;</li> </ul>
38.	<p>Малын тэжээлийн ургамлын элит болон сортын үр үйлдвэрлэх технологи</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Уур амьсгалын өөрчлөлтөнд зохицсон олон наст тэжээлийн ургамлыг тариалах шинэ технологи боловсруулах;</li> <li>- Монгол орны нөхцөлд нутагших боломжтой олон наст ургамлын сортыг шалгаруулж, үрийн нөөц бүрдүүлэх;</li> <li>- Говь, цөлийн бүсэд ургах боломжтой ургамлын төрөл сорт шалгаруулах;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Ногоон конвейрт тариалах ургамлын технологи боловсруулах;</li> <li>- Шимт чанартай тэжээлийн түүхий эдийн нэр төрлийг нэмэгдүүлж, шинэ нөөц бий болгох;</li> </ul>
39.	<p>Бэлчээрийн болон эрчимжсэн аж ахуйн төлийн тархмал өвчинтэй тэмцэх өсөлтийн физиологид суурилсан арга, бэлдмэлийн технологи</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Дархлаат уураг сүү орлуулагч болон хосолмол үйлчилгээт лактоферрины биобэлдмэлийн технологи, хэрэглэх арга;</li> <li>- Гипогликеми, аминдэмийн дутагдал болон цус багадалтаас сэргийлж, дархлаа дэмжих үйлдэлтэй ашигтай бактерийг сонгон шалгаруулж, биобэлдмэлд хэрэглэх арга боловсруулах;</li> <li>- Эрчимжсэн аж ахуйн нөхцөл дэх тугалын амьсгалын замын өвчний шалтгаан, эмгэг жамын тандан судалгаа явуулж, ялгаварлан оношлох хурдавчилсан арга боловсруулах;</li> </ul>
40.	<p>Бог малын мялзан өвчний вакцины загвар бэлтгэн турших</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Бог малын мялзан өвчний омгийг дамжмал эсийн өсгөвөрт өсгөвөрлөн вакцины загвар бэлтгэх;</li> <li>- Бэлтгэсэн вакцины загварыг in vivo орчинд турших;</li> <li>- Загвар вакцины тэжээлт орчин, хуурайшуулах технологи боловсруулах;</li> <li>- 2-3 төрлийн загвар вакцины дархлааны үргэлжлэх хугацааг харьцуулан тодорхойлох;</li> </ul>
41.	<p>Зарим хорт ургамлын нөлөөнөөс малын эрүүл мэндийг хамгаалах оновчтой арга боловсруулах</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Бэлчээрийн малд хордлого үүсгэдэг зонхилох ургамлуудыг илрүүлэн хордлогын зэргээр ангилах;</li> <li>- Газарзүйн мэдээллийн системийн ArcGIS 10.6 програм ашиглан зонхилон тохиолдох хорт ургамлуудын тархацыг тогтоож, зураглал гаргах;</li> <li>- Бэлчээрийн малыг ургамлын хордлогоос сэргийлэх, оношлох, тэмцэх арга боловсруулах;</li> </ul>
42.	<p>Буудайн нутагшсан сортуудын эх үр, элит үр үйлдвэрлэл</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Үрийн гарцыг нэмэгдүүлэн 72-76%-д хүргэх үр үйлдвэрлэлийн дэвшилтэт технологи боловсруулах;</li> <li>- Буудайн сортуудын хээрийн цухуйцыг 10-15%-иар нэмэгдүүлэх үрийн тохиромжтой фракцийг тогтоох;</li> <li>- Төв болон өндөрлөг уулын бүсэд тохирсон ган халуунд тэсвэртэй Дархан-144, Дархан-166, Дархан-131, Дархан-181, Дархан-193 сортуудын үрийн анхан шатны эх материалыг бий болгох;</li> <li>- Элит үр нийт 600 тн үйлдвэрлэж үр шинэчлэлт хийх;</li> </ul>

<p>43.</p>	<p>Эрт болцтой, абиотик стресст тэсвэртэй хүнсний ногооны удам, сорт, бий болгох, шалгаруулах, элит үр үржүүлэг /Увс, Дорнод, Төв бүс/  2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Селекцийн эрлийжүүлэг, мутацийн аргаар хүлэмжийн амтат чинжүүний бутан дээрээ эрт боловсордог, махлаг эд зузаантай 8-10 шинэ удам сонгон авах;</li> <li>- Газар тариалангийн төв болон баруун, зүүн бүсийн нөхцөлд абиотик стресст тэсвэртэй, нэн эрт болцтой, өвчин, хортонд тэсвэртэй сортуудыг шалгаруулж, ирээдүйтэй болон нутагшсан сортоор дэвшүүлэх;</li> <li>- Эртийн байцааны ургацын жигдрэлт сайтай 10 удам бий болгох;</li> <li>- Шинэ таримал порей сонгины агротехнологийн судалгаа хийх;</li> <li>- Шанцай, бууцай, гоньд, улаан лууван болон бөөрөнхий ба урт сонгины элит болон нутагшсан сортын 2000-2500 кг үржүүлэх;</li> </ul>
<p>44.</p>	<p>Ургамлын гаралтай биопестицид үйлдвэрлэхэд ашиглах ургамлын генетикийн судалгаа хийж, ашигт ургамлын плантаци байгуулан үржүүлэх  2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Биопестицидийн зориулалтаар ашиглаж байгаа ургамлын үйлдвэрлэлийн болон биологийн нөөцийг ургамал газарзүйн Хангай, Хөвсгөл, Хэнтий, Монгол Дагуурын тойрогт тодорхой цэгүүдэд тогтоож, ex-situ нөхцөлд тарималжуулсан амьд цуглуулгын сан бүрдүүлэх;</li> <li>- Биопестицидийн үйлчилгээтэй ургамлуудын биологийн идэвхт нэгдлийг илрүүлэх;</li> <li>- Биопестицидийн үйлчилгээтэй ургамалд генетикийн судалгаа хийх, үржүүлгэнд хэрэглэх үр тарьцын материалыг бий болгох;</li> <li>- Ургамлын зүйл тус бүрийг дэвсэгт тарьж, үр тарьц, үржүүлгийн материал бүрдүүлэн ургамлын плантацийн талбайд ургуулах;</li> <li>- Сонгосон ургамлаас in vitro нөхцөлд бичил ургамал үржүүлэх тарьцын материалын сантай болж, технологийн заавар боловсруулах;</li> </ul>
<p>45.</p>	<p>Таримал ургамлын гол хортны шимэгч шавжийн төрөл зүйлийг илрүүлэх, тэдгээрийг хамгаалах, хэрэглэх биологийн арга боловсруулах  2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Тоонолжин цэцэгт таримлын хортон байцааны хивэн эрвээхэй (<i>Plutella xylostella</i>), сармаг манжингийн цагаан эрвээхэйн (<i>Pieris rapae</i>) хүрэнцэр, хүүхэлдэйн ангуучин болон шимэгч шавжийг илрүүлэх, төрөл зүйлийг тогтоох, тэдгээрийн гарах хугацаа, фенологи хөгжлийг тодорхойлж, лабораторийн нөхцөлд үржүүлэх, хэрэглэх аргыг боловсруулах;</li> <li>- Байцааны хивэн эрвээхэйн (<i>Plutellavex-Granulovirus SC</i>) эсрэг вирусийн бэлдмэл туршин хэрэглэх арга, зөвлөмж боловсруулах;</li> <li>- Үр тарианы хөнөөлт царцаа <i>Oedaleus asiaticus</i>, <i>Calliptamus abbreviates</i>, <i>Arcyptera meridonalis</i>-ийн шимэгч шавжийг илрүүлэх, төрөл зүйл, үржил хөгжлийг тогтоох, тэдгээрийн ач холбогдлыг тодорхойлох;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Чацарганы ялааны (<i>Rhagoletis batava</i>) бие гүйцсэн болон хүүхэлдэйн шимэгч шавжийг илрүүлэх, төрөл зүйлийг тогтоох, паразит нематодыг (<i>Entonem -F (Steinernema feltae Filippev)</i>) турших, хэрэглэх арга технологийг боловсруулах;</li> </ul>
46.	Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих төрийн бодлогын эдийн засгийн хөшүүргийг боловсронгуй болгох нь  2020-2022	<ul style="list-style-type: none"> <li>- Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих эдийн засгийн хөшүүрэг /татвар, төсвийн татаас, хөрөнгө оруулалт, зээлийн бодлого, үнэ/-ийн дүн шинжилгээ, зөвлөмж;</li> <li>- Эдийн засгийн хөшүүргүүдийн үндэслэл, тооцоолол;</li> </ul>
47.	Хүн амын өргөн хэрэглээт хүнсний бүтээгдэхүүний аминхүчил, тосны хүчлийн найрлага, найрлагын мэдээллийн сан (FCT) бүрдүүлэлт  2020-2022	<ul style="list-style-type: none"> <li>- Өргөн хэрэглээний 300 нэр төрлийн хүнс, хүнсний бүтээгдэхүүн тус бүрт үл орлогдох болон орлогдох аминхүчил 15 үзүүлэлт, тосны хүчлийн 10 үзүүлэлт, эслэг бүхий биохимийн найрлага тодорхойлох;</li> <li>- Хүнс, хүнсний бүтээгдэхүүний найрлагын мэдээллийн сан бүрдүүлэх;</li> <li>- Аминхүчил, тосны хүчил (транс тос багтана) тодорхойлох нарийн мэдрэмжит багажит анализийн арга, стандарт боловсруулж батлуулах;</li> <li>- Хүнс, хоолны шим тэжээлийн найрлага тооцоолох програм бий болгох;</li> </ul>
48.	Ноос, ноолуур, хөөврөн нэхмэл даавууны гүйцэтгэн боловсруулалтын түвшинг сайжруулах технологийн судалгаа, боловсруулалт  2020-2022	<ul style="list-style-type: none"> <li>- Уртаар хэмжигддэг төрөл бүрийн нэхмэл материал, бүтээгдэхүүний эцсийн гүйцэтгэн боловсруулах чиглэлийн сүүлийн үеийн дэвшилтэт технологи, техник тоног төхөөрөмжийг судлах, сонгох;</li> <li>- Ноос, ноолуур, хөөврөн болон хольцтой нэхмэл даавууны гүйцэтгэн боловсруулах технологийн горимыг тус бүрт нь боловсруулах;</li> <li>- Уртааш метрээр үйлдвэрлэх зуун хувийн цэвэр ноос, ноолууран ширхэгтээр хийсэн нарийн даавууны 2-3 стандарт боловсруулах, батлуулах;</li> <li>- Зэвсэгт хүчин, цагдаа зэрэг төрийн албан хаагчдын дүрэмт хувцасны шаардлага стандартад нийцсэн нэхмэл даавууны гүйцэтгэн боловсруулах технологийг бий болгох, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, стандарт боловсруулах;</li> <li>- Уртааш метрээр үйлдвэрлэх холиотой ширхэгтээр хийсэн даавууны стандарт боловсруулах, батлуулах /драп, монгол дээл, костюм, цамц, өмд, нярай хүүхдийн өлгий, хөнжил зэрэг/;</li> </ul>
49.	Арьс ширний үйлдвэрлэлээс гарч буй дагалдах түүхий эдээр нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн	<ul style="list-style-type: none"> <li>- Арьс ширний үйлдвэрлэлийн хаягдлын хэмжээг стандарт ангиллын дагуу тогтоох судалгаа;</li> </ul>

	<p>үйлдвэрлэх биотехнологийн судалгаа, боловсруулалт</p> <p>2020-2022</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хаягдлыг бууруулах, дахин ашиглах, хатуу хаягдлаар боловсруулах бүтээгдэхүүний судалгаа, технологи /хром агуулсан болон агуулаагүй хатуу хаягдлын төрлөөр, үүнд: халим, год, хромтой болон хромгүй зах өөдөс/</li> <li>- Хатуу хаягдлаар боловсруулсан бүтээгдэхүүний стандарт боловсруулан батлуулах;</li> <li>- Хатуу хаягдал ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэвэр технологи боловсруулах, зөвлөмж гаргах;</li> </ul>
<b>Эрүүл мэндийн яам</b>		
50.	<p>Хүүхдийн хорт хавдрын оношилгоо, эмчилгээний зарим асуудалд</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Ходжкины бус лимфомын эдэд хийх иммуногистохимийн шинжилгээний аргачлал;</li> <li>- Нейробластом хавдрын эдэд хийх иммуногистохимийн шинжилгээний аргачлал боловсруулах;</li> <li>- Зөөлөн эдийн хорт хавдрын эдэд хийх иммуногистохимийн шинжилгээний аргачлал боловсруулах;</li> <li>- Гепатобластом хавдрын эдэд хийх иммуногистохимийн шинжилгээний аргачлал боловсруулах;</li> <li>- Юнга сарком, остеосарком хавдрын эдэд хийх иммуногистохимийн шинжилгээний аргачлал боловсруулах;</li> <li>- Ретинобластом хавдрын эдэд хийх иммуногистохимийн шинжилгээний аргачлал боловсруулах;</li> <li>- Нефробластом хавдрын эдэд хийх иммуногистохимийн шинжилгээний аргачлал боловсруулах;</li> <li>- Хүүхдийн зонхилон тохиолдох хорт хавдрын оношилгоо, эмчилгээний эмнэлзүйн стандарт, заавар тус бүр боловсруулах;</li> <li>- Хүүхдийн хорт хавдрын эдийн шинжилгээ хийх иммуногистохимийн шинжилгээний шинэ арга аргачлалыг нэвтрүүлэх;</li> </ul>
51.	<p>Трофобласт өвчний оношилгоо, эмчилгээний асуудлыг боловсронгуй болгох нь</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Цулцан хураа өвчний дараах трофобласт өвчин үүссэн судалгаа хийх;</li> <li>- Трофобласт өвчин оношлогдсон тохиолдол тус бүрт иммуногистохимийн шинжилгээ хийх;</li> <li>- Эмчилгээний аргыг боловсронгуй болгох;</li> <li>- Эмчилгээний заавар, стандарт боловсруулах;</li> <li>- Иммуногистохимийн шинжилгээ хийж үр дүнгээр нь аргачлал боловсруулах;</li> </ul>
52.	<p>Натри хөөгч пептидийн сорилыг эмнэлгийн практикт нэвтрүүлэх нь</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Зүрхний архаг дутагдлын эрт илрүүгийн судалгаа хийх;</li> <li>- Эмчилгээний заавар, удирдамжийг боловсронгуй болгох;</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Оношилгооны шинэ технологийг бүх шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх;</li> </ul>
53.	<p>Хүүхдийн сүрьеэгийн өвчлөл ба нийгэм, орчны хүчин зүйлсийн хамаарлыг тодорхойлох судалгаа</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүүхдийн сүрьеэгийн өвчлөлийн тархвар зүйн өнөөгийн байдлыг тогтоох;</li> <li>- Дотоод орчны агаарын чанар ба хүүхдийн сүрьеэгийн өвчлөлийн хоорондын хамаарал тогтоох;</li> <li>- Өрхийн орлого эдийн засгийн байдал ба хүүхдийн сүрьеэгийн өвчлөлийн хоорондын хамаарал тогтоох;</li> <li>- Хүүхдийн сүрьеэгээс урьдчилан сэргийлэх талаарх зөвлөмж, гарын авлага боловсруулах;</li> </ul>
54.	<p>Улаанбаатар хотын орон сууцнуудын радоны хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн судалгаа</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Улаанбаатар хотын нүүрсэн блок ашиглаж барьсан орон сууцны дотоод орчны агаарын радоны агууламжийн түвшинг тогтоох;</li> <li>- Оршин суугчдад радоноос үзүүлэх нөлөөллийг судлах;</li> <li>- Зөвлөмж, гарын авлага гаргах;</li> </ul>
55.	<p>Монгол хүний титмэн артерийн нарийсал ба шохойжилтыг компьютерт томо-коронарографиар оношилж, нарийсал ба шохойжилтод нөлөөлөх биомаркеруудыг судлах</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол хүний титмэн судасны нарийсал ба шохойжилтыг компьютерт томо-коронарографиар оношлох;</li> <li>- Монгол хүний титмэн судасны нарийсал ба шохойжилтод нөлөөлөх биомаркеруудыг тодорхойлох;</li> <li>- Монгол хүний титмэн судасны шохойжилт, яс сийрэгжилт хоорондын хамаарлыг судлах;</li> <li>- Компьютерт томо-коронарографийн шинж тэмдгүүдээр титмийн артерийн хатуурлын товрууг илрүүлэх арга аргачлалыг боловруулах;</li> <li>- Эмнэлзүйн заавар боловсруулах;</li> </ul>
56.	<p>Амьсгалын замын үрэвсэлт эмгэгийн эсрэг, дархлаа дэмжих үйлдэлтэй Иммунофлю уусдаг мөхлөг, архинд донтох эмгэгийг эмчлэх нөлөөтэй Алкуремон шахмал эмийн эмнэлзүйн судалгаа</p> <p>2020-2021</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Амьсгалын замын хурц үрэвсэлт өвчнийг эмчлэх, урьдчилан сэргийлэх, дархлаа дэмжих Иммунофлю, Архины дуршлыг бууруулж хордлого тайлах Алкуремон эмийн эмнэл зүйн судалгааны арга зүйг боловсруулах;</li> <li>- Амьсгалын замын хурц үрэвсэлт өвчнийг эмчлэх, урьдчилан сэргийлэх, дархлаа дэмжих Иммунофлю, Архины дуршлыг бууруулж хордлого тайлах Алкуремон эмийн эмнэлзүйн судалгааг хийх;</li> <li>- Хоёр шинэ эмийн үйлдвэрлэх технологийн заавар, үйлдвэрлэгчийн фармакопейн өгүүлэл боловсруулан батлуулах;</li> </ul>
57.	<p>0-4 насны эрүүл хүүхдийн дархлааны эс болон уургийн дундаж үзүүлэлтийг тогтоон, монгол хүүхдийн дархлаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>- 0-4 насны эрүүл хүүхдийн дархлааны эсүүдийн дундаж хэмжээг тогтоох;</li> <li>- 0-4 насны эрүүл хүүхдийн дархлаа чадамжит уураг (хавсарга, эсрэг бие)-ийн дундаж агууламжийг тогтоох;</li> </ul>

	чадамжийг үнэлэх лавлагаа хэмжээг тодорхойлох  2020-2021	- Эрүүл монгол хүүхдийн дархлаа чадамжийг үнэлж, дархлааны эсүүдийн лавлах хэмжээг тодорхойлох; - Эмнэлзүйн стандарт, зөвлөмж боловсруулж, батлуулах;
<b>Эрчим хүчний яам</b>		
58.	Цахилгаан эрчим хүч нөөцлөх технологийн судалгаа  2020-2021	- Цахилгаан эрчим хүч нөөцлөх боломжийн судалгаа; - Орчин үеийн өндөр багтаамжтай цэнэг хураагуурын судалгаа;
59.	Эрчим хүчний хэмнэлтийн үр ашгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох судалгаа  2020-2021	- Эрчим хүчний хэмнэлтийн үр ашгийн үзүүлэлтүүдийн судалгаа; - Эрчим хүчний эцсийн хэрэглэгчдийн хэрэглээний судалгаа;